



ДУАГ

ДУНДГОВЬ АЯМГИЙН АУДИТЫН ГАЗАР

“Орон нутгийн хөгжлийн сангийн
2016 оны зарцуулалт”-д хийсэн
нийцлийн аудитын тайлан /ҮАГ-
НАГ/2017/НА-01/



ОНХС-гийн хөрөнгийн
төлөвлөлт, гүйцэтгэлд
тавих хяналт болон
иргэдийн оролцоо
хангалтгүй хэвээр байна.



Мандалговь
2017 он



<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	4
Дундговь аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-7
Дарга, тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг	БҮЛЭГ 1. ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, хуваарилсан боловч хандивын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.	
Аудитын менежер Х.Наранцацрал	1.1. Аймгийн ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөжээ.	8
Ахлах шинжээч Д.Ихбаяр	1.2. ОНХС-гийн эх үүсвэрийг хуульд заасан төрөл тус бүрээр төлөвлөх, бүрдүүлэх ажил хангалтгүй байна	8-9
Аудитор Х.Гарам	1.3. ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг журмын дагуу тооцон хуваарилж, төлөвлөгөөний дагуу санхүүжилтийг бүрэн олгожээ.	9-10
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	БҮЛЭГ 2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргийг санхүүжүүлж байгаа боловч сангийн хөрөнгийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог бүрэн хангаагүй, зарим сумдад өмнөх аудитаар илэрсэн зөрчил давтагдсаар байна.	
	2.1 Зарим сумд өөрийн орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн байна.	10-12
	2.2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г иргэдэд нээлттэй хэлэлцүүлэн санал авч эрэмбэлсэн боловч иргэдийн оролцоог бүрэн хангаагүй байна.	12-16
	2.3. Ихэнх сумд хууль, журмын дагуу зураг, төсөв нь хийгдсэн ажлуудыг баталж санхүүжүүлж хэвшсэн байна.	17
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот	2.4. Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил зарим талаар хууль, журамд нийцээгүй байна.	17-20
	2.5. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргийг санхүүжүүлжээ.	20-22
2017 оны 4 дүгээр сар	2.6. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд аймаг, сумаас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлдэг ч зарим суманд чанаргүй хөрөнгө бэлтгэгдсээр байна.	22-24

2.7. Өлзийт, Сайхан-Овоо сумд ОНХС-гийн санхүүжилтээр бий болсон 30.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байна.	24-27
БҮЛЭГ 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй ч хэрэгжилтийг зааврын дагуу мэдээлсэн байна.	
3.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба зарим сумдад төлөвлөгөөт шалгалтыг хийсэн байна.	27-28 28
3.2. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу тайланд дүн шинжилгээ хийгдээгүй байна.	28-29
3.3. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу ил тод бүрэн мэдээлжээ.	29
3.4. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь бусад хууль тогтоомжтой нийцсэн байна.	29-30
3.5.Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.	
Дүгнэлт	31
Зөвлөмж	32-33
Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал	33
Шалгагдагч байгууллагаас ирсэн санал, тайлбар	34-35
Аудитын газрын тайлбар	36
Тайлан баталгаажуулах тушаал	37-43
Тайлангийн хавсралтууд	44-63

ТОВЧИЛСОН ҮГС

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗҮ	Зөвлөх үйлчилгээ
БИНХ	Багийн иргэдийн нийтийн хурал
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНО	Олон нийтийн оролцоотой
ХА	Харьцуулалтын арга
ХТШ	Хязгаарлагдмал тендер шалгаруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШГБ	Шууд гэрээ байгуулах
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ХАА	Худалдан авах ажиллагаа
ЗХЗ	Захиалагчийн хяналтын зардал
ХО	Хөрөнгө оруулалт

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/12 дугаар тушаал, Дундговь аймгийн Аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны төлөвлөлт, хуваарилалт, бүрдүүлэлт, зарцуулалт хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдэлийг бууруулах талаар санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудыг дэвшүүлэн аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн эсэх,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан эсэх,

Аудитын хамарсан хүрээ: Аймгийн ИТХ, Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын СТСХ, ХОХБТХ, 15 сум, багийн Засаг дарга, БИНХ-ын материалыг хамруулж, 2016 онд орон нутгийн хөгжлийн санд улсын төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг болон бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаарх ажлын тайлан, анхан шатны болон НББ-ийн журнал бусад холбогдох материал, эрх зүйн актуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхдээ Аудитын олон улсын стандарт, Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, нийцлийн аудитын түр журам, гарын авлага, арга зүйг ашиглан, тэргүүлэх аудиторовын баталсан хөтөлбөрийн дагуу аудитын дараах горимыг хэрэгжүүлэв. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах, судалгаа хийх;
- Цуглуулсан мэдээ судалгаанд дүн шинжилгээ, харьцуулалт хийх;
- *ᠨᠣᠢ дᠠᠢ ᠣᠠᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠ, ᠣᠢ ᠡᠠᠢ ᠠᠠᠢ ᠣ ᠢ ᠣᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠ* үзэвчээр мэдээ, судалгаа гаргуулах;
- ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, хөтөлбөртэй танилцан нөхцөл байдлын шинжилгээ хийх.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль, тогтоомж, шалгуур үзүүлэлт: Дараах хууль эрхийн актын холбогдох заалтыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн хяналт шалгалтын стандарт;

- Төрийн аудитын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2012 оны 244, 290, 264 дүгээр тушаал;
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал;
- Бусад холбогдох эрх зүйн актууд;

Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа: Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, нийцлийн аудитын багийн ахлах шинжээч Д.Ихбаяр, аудитор Х.Гарам нар 2017 оны 2 дугаар сарын 29-ний өдөр эхлэн, 4 дүгээр сарын 18-ныг дуустал хугацаанд гүйцэтгэлээ.

Аудитын дүн: Аудитаар нийт 1,119.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 1,119.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлжээ.

Аудитаар илэрсэн зөрчлийг агуулгаар нь ангилбал:

- ❖ Зориулалтын бус зардалд зарцуулсан 166.2 сая төгрөг буюу 14.8 хувь;
- ❖ Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж санхүүжүүлсэн 524.6 сая төгрөг буюу 46.8 хувь;
- ❖ Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн 216.3 сая төгрөг буюу 19.3 хувь;
- ❖ Бүртгэл, тайланд тусгаагүй 171.4 сая төгрөг буюу 15.3 хувь;
- ❖ ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй 10.6 сая төгрөг буюу 0.9 хувь;
- ❖ Захиалагчийн хяналт тавиагүй /Хөрөнгө, өр төлбөрийг бүртгэлд тусгаагүй/ 30.7 сая төгрөг буюу 2.7 хувийг тус тус эзэлж байна. (Хавсралт:7)

Аудитын явцад аймгийн Ахмадын хороотой гэрээ байгуулан, орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын талаар иргэдээс санал асуулга авах ажлыг гүйцэтгүүлж, судалгааны дүнг нэгтгэн, харьцуулалт хийж аудитын тайланд тусгасан.

Санал асуулгад тус аймгийн 15 сумын хөдөлмөрийн насны 2803 иргэн хамрагдсаны дотор эрэгтэй 1052, эмэгтэй 1751 иргэн оролцож, санал бодлоо илэрхийлсэн байна. Санал асуулгад оролцогчдын 27.7 хувь нь 18-35 насны залуучууд, 39.2 хувь нь 52-оос дээш насныхан, үлдсэн 33.1 хувь нь 36-51 насны иргэд байлаа.

Санал асуулгад оролцсон иргэдийн 25 хувь буюу 702 нь дээд, 13.5 хувь буюу 378 нь тусгай дунд, 26 хувь буюу 730 нь бүрэн дунд, 638 буюу 22.8 хувь нь бүрэн бус дунд, 317 буюу 11.3 хувь нь бага боловсролтой иргэд эзэлж байна.

Үндсэн мэдээлэл:

Төсвийн тухай хуульд “Орон нутгийн хөгжлийн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан.

Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлд ОНХНС-гаас тус аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 4,852.1 сая төгрөгөөр баталсныг Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар 4,114.7 сая төгрөг болгон өөрчилсөн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ОНХС-д олгох шилжүүлгийг тооцоходоо Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг мөрдөж байна.

Орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримтлан хэрэгжүүлж байна.

Аймаг, сумын ОНХС-д 2016 онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас гүйцэтгэлээр 4,114.7 сая төгрөгийн санхүүжилтийг авч, орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас 443.9 сая, зарлагыг хэмнэх замаар болон ОНХС-гийн 2015 оны үлдэгдэл орлогоор 916.3 сая, хандив тусламжаар 19.5 сая, нийт 5,494.4 сая төгрөгийн орлогын эх үүсвэр төвлөрсөн байна.

ОНХС-гийн хөрөнгөөр аймаг, сумдад он дамжин үргэлжлэх 2016, 2017 онд хэрэгжүүлэх 209, нийт 229 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас ОНХНС-гаас олгосон орлогын шилжүүлгийн хэмжээ буурсан тул төлөвлөсөн ажлын 79.0 хувь буюу 181 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 1.8 хувь буюу 4 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжиж, 19.2 хувь буюу 44 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Бүлэг 1. ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, хуваарилсан боловч хандивын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

1.1 Аймгийн ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөжээ.

ОНХНС-аас 2016 онд Дундговь аймгийн ОНХС-д 4,114.7 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хуваарилсан.

ОНХНС-аас хуваарилсан орлогын шилжүүлгийг аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 59.2, 59.3-т заасан хувь, итгэлцүүрээр тооцож, 60 хувь буюу 2,468.8 сая төгрөгийг сумдад, 40 хувь буюу 1,645.9 сая төгрөгийг аймгийн төвд тус тус хуваарилан, хэрэгжүүлсэн байна. (*Хавсралт 2*)

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны нийт орлогыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 10 дугаар тогтоолоор 4,852.1 сая төгрөгөөр баталж, 2016 оны 10 дугаар тогтоолоор ОНХНС-аас олгох шилжүүлгийг 737.4 сая төгрөгөөр бууруулж, оны эхний үлдэгдэл орлогоос 916.3 сая төгрөг, орон нутгийн орлогын давсан орлогоос 444.5 сая төгрөг, хандив тусламжийн орлогоос 54.0 сая төгрөгийн орлого нэмэгдэж төвлөрүүлэхээр тооцон 677.4 сая төгрөгөөр буюу 12.2 хувиар нэмэгдүүлэн тодотгожээ. (*Хавсралт 1*)

1.2 ОНХС-гийн эх үүсвэрийг хууль, журамд заасан төрөл тус бүрээр төлөвлөх, бүрдүүлэх ажил хангалтгүй байна.

Аймгийн хэмжээнд ОНХНС-гаас олгох шилжүүлгээс гадна 2015 оны төлөвлөгөөнөөс давсан орлого 444.5 сая төгрөг, аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдлээс 916.3 сая төгрөг, хандив, тусламж болон бусад орлогоос 54.0 сая төгрөг /Гурвансайхан, Өлзийт, Хулд, Дэлгэрхангай сумд/ төвлөрүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн хөгжлийн санд 2016 онд ОНХНС-гаас 4,114.7 сая төгрөг, урьд оны үлдэгдэл 916.3 сая төгрөг, татварын орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогоос 443.9 сая төгрөг, хандив, тусламж болон бусад орлогоор 19.5 сая төгрөгийг тус тус төвлөрүүлж, гүйцэтгэлээр 4,831.9 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 662.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2016 онд аймаг, сумдын ОНХС-д орон нутгийн татварын давсан орлого болон хандив, тусламжийн орлогоос нийт 463.4 сая төгрөгийг төвлөрүүлжээ. (*Хавсралт 2,3.*) Нийт орлогын эх үүсвэрийг график 1 –ээр харуулбал:

График: 1



Диаграмаас харахад аймаг сумдын төсвийн төсөлд ОНХС-ийн орлогыг хуульд заасан нэр төрөл тус бүрээр /ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлгээс бусад/ тооцоолж төлөвлөх, сангийн орлого нэмэгдүүлэхэд санаачилга гаргах шаардлагатай байна.

Гурвансайхан сум хандив, тусламжийн орлогоос 50.0 сая төгрөг төвлөрүүлж наадмын талбайн засвар хийх, наадам зохион байгуулах зардалд зарцуулахаар төлөвлөсөн боловч 30.0 сая төгрөгийн хандивын

орлогыг ОНХС-д төвлөрүүлэлгүйгээр ТББ-ын /сумын Ахмадын хорооны/ дансаар хүлээн авч ЗДТГ-ын хамтын сангийн дансруу шилжүүлэн, зарцуулсан байна.

Энэхүү зөрчил нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйл 60.2¹, 60.2.5², 4.1.14³, 5.1.2⁴, 6.1⁵, 6.3.4⁶ дахь заалтыг тус тус зөрчсөн тул зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага өгсөн.

Засгийн газрын 2012 оны 30 тогтоолоор батлагдсан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 2.2.5 дахь заалтад тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламжийн орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар нэмэлт өөрчлөлт оруулах саналыг дээд шатны байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1.3 ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлгийг журмын дагуу тоохон хуваарилж, төлөвлөгөөний дагуу санхүүжилтийг бүрэн олгожээ.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2016 онд батлагдсан санхүүжилтийг бүрэн олгосон. /4,114.7 сая төгрөг /

Аймгийн ОНХС-гаас олгох шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59.2-т заасан хувь, итгэлцүүрээр тооцож 60 хувь буюу 2,468.8 сая төгрөгийг сумдад, 40 хувь буюу 1,645.9 сая төгрөгийг аймгийн төвд тус тус хуваарилахаар төлөвлөж, батлагдсан хуваарийн дагуу олгожээ.

¹ Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

² тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж.

³ "орлого" гэж тухайн этгээдийн дотоод гүйлгээнээс бусад гаднаас хүлээн авах бүх төрлийн гүйлгээг;

⁴ төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;

⁵ Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

⁶ төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх.

Аудитын явцад аймгийн СТСХ-ийн тооцсон индексээр анх олгогдохоор баталсан төсөв болон сумдад хуваарилсан орлогын шилжүүлгийг дахин тооцоолоход зөрүү гараагүй болно.

Гүйцэтгэлээс үзэхэд бүх сумд батлагдсан төлөвлөгөөт санхүүжилтээ бүрэн авсан байна. (Хавсралт: 2,3)

Бүлэг 2 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргийг санхүүжүүлж байгаа боловч сангийн хөрөнгийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог бүрэн хангаагүй, зарим сумдад өмнөх аудитаар илэрсэн зөрчил давтагдсаар байна.

2.1 Зарим сумд тухайн орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй хөтөлбөр, төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна.

Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журамд зааснаар ОНХС-гаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр болон тухайн орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан байх ёстой.

Аймаг, сумд тухайн жилийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд заасны дагуу ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргажээ.

ОНХС-гийн хөрөнгийг Эрдэнэдалай, Баянжаргалан сумд үр дүнтэй томоохон хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд зарцуулсан бол зарим сумд ихэвчлэн жижиг буюу урсгал шинжтэй арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна. Тухайлбал:

- ❖ Энгийн уурхайн худаг засварлах /6 сум /;
- ❖ Тоног хөрөөрөмж худалдан авах /6 сум/;
- ❖ Өвс тэжээл авах /4 сум/;
- ❖ Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн сургалт, хувцас авах /2 сум/;
- ❖ Соёлын өв хамгаалах /Говь-Угтаал сум/;
- ❖ Адууны генетик шинжилгээ / Өндөршил сум /;
- ❖ Их говийн тэмээ 2016 арга хэмжээ /Өлзийт сум /;
- ❖ Замын тэмдэг, тэмдэглэгээ / 2 сум /;

Сумдад орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлт байхгүй, ирээдүйд үр өгөөж өгөх хөрөнгө оруулалтад биш ойрын хэрэгцээ шаардлагыг хангахад ОНХС-гийн хөрөнгийг зарцуулсаар байна.

Өнгөрсөн жил ОНХС-гийн хөрөнгөөр Өндөршил, Гурвансайхан, Дэлгэрхангай сумд “Сумын ерөнхий төлөвлөгөө” хийлгэсэн, бусад сумдын хувьд тус ажлыг төлөвлөсөн боловч бүрэн хийгдээгүй дутуу гүйцэтгэлтэй, маргаантай байна.

Дээрх сумдын хувьд цаашид тухайн орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлттэй болох ажлаа яаралтай шийдвэрлүүлж, түүнтэй уялдуулан томоохон, хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх нь зүйтэй.

Аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр 229 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 218 арга хэмжээ буюу 95.1 хувийг тухайн оны үндсэн чиглэлдээ тусгажээ.

Хүснэгт: 1

ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлтийн судалгаа

№	Аймаг, сумын нэр	Төлөвлөсөн арга хэмжээ	тухайн жилийн үндсэн чиглэлд тусгасан арга хэмжээний тоо	ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт		
				Иргэдийн саналыг авч эрэмбэлсэн эсэх	ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан эсэх	Өөр бусад эх үүсвэртэй давхардуусан эсэх.
1	Дэлгэрцогт	10	10	Тийм	Тийм	Үгүй
2	Дэрэн	12	12	Тийм	Тийм	Үгүй
3	Говь-Угтаал	8	6	Тийм	Тийм	Үгүй
4	Цагаандэлгэр	11	11	Тийм	Тийм	Үгүй
5	Баянжаргалан	6	6	Тийм	Тийм	Үгүй
6	Өндөршил	12	11	Тийм	Тийм	Үгүй
7	Гурвансайхан	11	10	Тийм	Тийм	Үгүй
8	Өлзийт	14	12	Тийм	Тийм	Үгүй
9	Хулд	7	7	Тийм	Тийм	Үгүй
10	Луус	13	12	Тийм	Тийм	Үгүй
11	Дэлгэрхангай	6	4	Тийм	Тийм	Үгүй
12	Сайхан-Овоо	10	10	Тийм	Тийм	Үгүй
13	Эрдэнэдалай	50	50	Тийм	Тийм	Үгүй
14	Адаацаг	23	22	Тийм	Тийм	Үгүй
15	Сайнцагаан	23	22	Тийм	Тийм	Үгүй
16	Аймаг	13	13	Тийм	Тийм	Үгүй
	Дүн	229	218			

Хүснэгтээс харахад 8 сум /Говь-Угтаал, Өндөршил, Гурвансайхан, Өлзийт, Луус, Дэлгэрхангай, Адаацаг, Сайнцагаан/ -д үндсэн чиглэлд тусгагдаагүй ажил төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. Энэ нь дээрх сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын зарим хэсгийг аймгаас баталж, сумдын ОНХС-гийн хөрөнгийг аймгийн чиг үүрэгт хамаарах хөрөнгө оруулалт /"Сум хөх бүрд цогцолборын дэд бүтэц цахилгаан дамжуулах шугам, дэд өртөөний барилга байгууламж, ногоон байгууламж", "Мандалговь цэцэрлэгт хүрээлэн байгуулах", "Жуулчны баазуудын хоорондох тэмдэг, тэмдэглэгээ"/ -ын ажилд зарцуулалсантай холбоотой байна.

Энэхүү зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.6.6⁷, 60 дугаар зүйлийн 60.1⁸, 14 дүгээр зүйлийн 14.1⁹, 14.1.17¹⁰, 14.2¹¹, 14.2.4¹², 63 дугаар зүйл¹³, 63.4¹⁴, Сангийн

⁷ тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр санхүүжүүлнэ

⁸ Тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий Орон нутгийн хөгжлийн сантай байна

⁹ Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна

¹⁰ аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.15, 14.1.16-д зааснаас бусад төсвийн.

¹¹ Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

¹² өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;

сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журмын 5 дугаар зүйлийн 5.10¹⁵ дахь заалтуудыг тус тус зөрчсөн тул зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

Дээрх сумд өөрийн орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй хөтөлбөр, төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 3.5¹⁶, 5.7¹⁷, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.2.7¹⁸ дахь заалттай нийцэхгүй байна.

Мөн аймаг, сумд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс ирүүлсэн саналыг нэгтгэж, БИНХ-д хэлэлцүүлэх урьдчилсан жагсаалтыг бэлтгэсэн боловч жагсаалтад Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсөв боловсруулах журам”-ын 12.2.2¹⁹-т заасан зарим үзүүлэлтүүдийг тооцож тусгаагүй байна.

Энэ нь тухайн төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлснээр бий болох үр өгөөж, ашгийг иргэд хэрхэн хүртэх, иргэдийн амьдралд нөлөөлөх нөлөөлөл зэргийг тооцоолж тусгалгүй урьдчилсан жагсаалтыг нэр төдий бэлтгэж байгааг харуулж байна.

2.2 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г иргэдэд нээлттэй хэлэлцүүлэн санал авч эрэмбэлсэн боловч иргэдийн оролцоог бүрэн хангаагүй байна.

Сумдад ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө журамд заасан хугацаанд багийн иргэдээс санал авч нэгтгэн эрэмбэлсэн боловч “ОНХС-гийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээг тодорхойлох маяг”-аар баталгаажуулах ажил хангалтгүй хэвээр байна.

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, иргэд, олон нийтийн оролцоог хангахдаа саналын хуудсаар нээлттэй санал асуулга авах, иргэдийн саналыг эрэмбэлж тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлсэн талаар баримт материал бүрдүүлсэн боловч иргэдийн оролцоо муу байгаа нь судалгаанаас харагдаж байна.

¹³ Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах

¹⁴ Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 63.3-т заасан саналыг хэлэлцэж, төсвийн төсөлд тусган, батална.

¹⁵ Сум, дүүргийн ИТХ-нь сум дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг төсөл тус бүрээр хэлэлцэн төсвийн төсөлд тусган “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын сум/ дүүргийн ИТХ-ын хуралдааны тогтоол /загвар маягт/-ын 3 дугаар хавсралтын дагуу батална.


¹⁶ ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг тухай шатны ИТХ-д хэлэлцүүлэн батлуулахаар хүргүүлэхдээ тухай орон нутгийн хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөөтэй хэрхэн уялдсан таларх дэлгэрэнгүй тайлбар үндэслэл иргэдийн хурлын санал тэдгээрийг тусгасан байдал гэсэн дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргана.

¹⁷ Баг хорооны Засаг дарга иргэдийн Нийтийн хуралд иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, харьяа сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн/хэрэв байгаа бол / хөгжлийн бодлоготой уялдуулан төслийн санал болон хурлын явцад иргэдээс гарсан саналыг нэг бүрчлэн хэлэлцүүлнэ.

¹⁸ сум, дүүргийн Засаг дарга эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, энэ журмын 6.3-т заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гаргаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвийн төслийн хамт өргөн мэдүүлнэ;

¹⁹ “Хөтөлбөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх, хэдэн хүн ашиг хүртэх, иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх, төслийн өртөг”

График 2



Аудитын явцад “ОНХС-гаас ямар төсөл арга хэмжээ санхүүжүүлэх боломжтой тухай мэдээлэл болон санал авах хуудас танай өрхөд ирж байсан уу?” гэсэн асуулгад судалгаанд оролцсон иргэдийн 42.4 хувь буюу 1190 иргэн саналын

хуудас ирдэггүй, мэдээлэл ч өгдөггүй, 38.6 хувь буюу 1083 иргэн саналын хуудас ирдэггүй ч хурал болох талаар мэдээлэл өгдөг гэж хариулснаас үзэхэд саналын хуудас, мэдээллийг тухай бүр өгөх ажлыг үр дүнтэй зохион байгуулдаггүйг илтгэж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд иргэдийн оролцоог хэр хангасан талаар судалж үзэхэд аймгийн хэмжээнд 15 сумын 13,885 өрхийн 29,652 иргэнээс 12,201 иргэнийг хамруулан саналыг авч жагсаалт гаргаж баталгаажуулсан нь 41.1 хувьтай байна. Энэ нь иргэдийн саналыг төлөөлөхүйц хангалттай түвшинд хүрээгүй, оролцоог хангаж чадаагүй боловч өмнөх онтой харьцуулахад 18.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь төлөвлөлтийн үед өрх, бүлгийн ярилцлага хийх, цахим хэлбэрээр санал авах зэрэг ажлууд аймаг, сумдад хийгдэхгүй байгаатай холбоотой юм.

Иргэдээс авсан саналыг сум тус бүрээр харуулбал:
Хүснэгт:2

№	Аудитад хамрагдсан сум	Багийн тоо	Өрхийн тоо /2015 он/	Хүн амын тоо/18 -аас дээш настай /	Санал авсан иргэний тоо	Санал авсан хувь
1	Дэлгэрцогт	3	537	1075	268	24.9
2	Дэрэн	4	599	1342	361	26.9
3	Говь-угтаал	3	536	1043	184	17.6
4	Цагаандэлгэр	4	383	689	175	25.4
5	Баянжаргалан	3	413	777	142	18.3
6	Өндөршил	2	467	938	215	22.9
7	Гурвансайхан	5	655	1401	345	24.6
8	Өлзийт	6	800	1588	361	22.7
9	Хулд	4	689	1524	821	53.9
10	Луус	3	544	1201	738	61.4


11	Дэлгэрхангай	4	652	1438	1008	70.1
12	Сайхан-Овоо	4	645	1434	290	20.2
13	Эрдэнэдалай	7	1679	3682	441	12.0
14	Сайнцагаан	9	4477	9679	6660	68.8
15	Адаацаг	5	809	1841	192	10.4
	Дүн	66	13885	29652	12201	41.1

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө, саналын хуудсаар нээлттэй санал асуулга авч, эрэмбэлэн нэгтгэж, тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлдэг ч сумдын хувьд иргэдийн оролцоо харилцан адилгүй, зарим сумдад хангалтгүй байна. Тухайлбал: Сайнцагаан сум нийт иргэдийнхээ 68.8 хувийг хамруулсан нь хамгийн өндөр, харин Адаацаг сум 10.4 хувийг хамруулсан нь хамгийн бага үзүүлэлттэй байна.

“ОНХС-гийн асуудал хэлэлцэх БИНХ-д та оролцдог уу?” гэсэн асуултад 50.4 хувь нь буюу 1,414 иргэн хааяа, 24.6 хувь нь огт оролцож байгаагүй гэж хариулснаас үзэхэд асуудлыг хэлэлцэж байгаа хуралд иргэдийг бүрэн оролцуулах талаар сум орон нутгийн хурал, засаг захиргааны байгууллагаас ихээхэн анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай асуудлуудыг иргэдээр хэлэлцүүлж чаддаг эсэх талаар иргэдийн 18.5 хувь нь цаанаас бэлтгэсэн асуудлуудын жагсаалтыг хэлэлцүүлж санал авдаг, 21.9 хувь нь оролцогч иргэдээс санал авч дэвшүүлэн хэлэлцүүлдэг гэсэн бол 34.2 хувь нь иргэдийн саналыг бараг сонсдоггүй, нэр төдий хурал болдог гэж хариулжээ. Графикаар харуулбал:

График 3



Диаграммаас харахад ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтыг гаргахдаа олон нийтийн оролцоог хангадаггүйгээс иргэдийн санал үнэн бодитой тусгагдахгүй байна. Иргэдээс ОНХС-тай холбоотой дараах саналууд ирсэн. Үүнд:

❖ Дээгүүр эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээгээ хэрэгжүүлэх тал дээр түлхүү анхаарч ажиллах,

❖ Цаанаасаа бэлдсэн


асуудлыг хэлэлцүүлсэн болж батлуулдаг буруу хэвшлийг зогсоох, БИНХ-ын хэлэлцүүлгийг боловсронгуй болгох,

❖ БИНХ-уудын ирцийг сайжруулж, нэр төдий хурал болгохгүй байх талаар анхаарч ОНХС-ийн санхүүжилтийн асуудалд иргэдийн /түүний дотор малчдын/ идэвхи оролцоог сайжруулах;

❖ БИНХ-д иргэдийн оролцоог хангахад анхаарах, БИНХ-ын зарыг иргэдэд сайн хүргэж хуралдуулж байх гэсэн саналууд ирсэн байна.

Мөн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтыг баталж ямар арга хэмжээг хэрэгжүүлэхээр болсон талаар иргэдэд мэдээлэл өгдөггүй нь иргэдээс авсан дараах судалгаанаас харагдаж байна. /График 4/

График 4



“ОНХС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр болсон төсөл, арга хэмжээний талаар мэдээллийг зарладаг уу?” гэсэн асуултад олонх нь буюу 47.1 хувь /1,321 иргэн/ нь зарладаг байх, гэхдээ би сонсоогүй гэж хариулсан, 19.1 хувь нь буюу 535 иргэн огт зарладаггүй гэж хариулжээ. Эндээс орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний мэдээллийг иргэд хомс авдаг гэж үзэхээр байна.

Аймаг, сумдын ЗДТГ-ын ажлын хэсэг нь БИНХ-аар дэмжигдсэн саналыг нэгтгэн ИТХ-д өргөн мэдүүлэх, нэгдсэн саналын жагсаалтыг гаргаж өгч байгаа боловч БИНХ-аар дэмжигдээгүй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөж, зориулалтын бус зардалд 5.4 сая төгрөгийг зарцуулсан зөрчил 2 суманд илэрлээ. Тухайлбал:

- *Өлзийт сум “Гамшгаас хамгаалах” сургалтын үйл ажиллагааны зардалд 0.7 сая;*
- *Цагаандэлгэр сум иргэдийн саналаар дэмжигдсэн “Ахмадын байрны засвар”-ын ажлын зориулалтыг өөрчилж монгол гэр худалдаж авах ажилд 4.7 сая*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3²⁰, 60.3.1²¹, 60.3.4²², 60.3.6²³, 63 дугаар зүйлийн 63.1²⁴, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журмын 4 дүгээр зүйлийн 4.4²⁵, 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай” журмын 12 дугаар

²⁰ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно

²¹ Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр арга хэмжээ

²² Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

²³ Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

²⁴ Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна

²⁵ Аймаг нийслэл сум дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх болон урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй

зүйлийн 12.2.5²⁶ дахь заалтуудын шаардлагад нийцээгүй тул зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага өгсөн.

Аудитын явцад аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний жагсаалтыг Төсвийн тухай хуульд нийцсэн эсэхийг хянахад БИНХ-аар дэмжигдээгүй, ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлж болохгүй, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв батлагдаагүй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг баталсан байна. Тухайлбал:

- ✓ Аймгийн төв “Төсөл хөтөлбөр арга хэмжээ”- ний зардалд 150.4 сая төгрөг, (*Хавсралт : 9*)
- ✓ Өлзийт сум “Төсөл, хөтөлбөр, арга хэмжээ”, *“Хууль сурталчилах хөтөлбөр, нийгмийн хүрээнд иргэдийн дунд зохион байгуулагдах хөтөлбөр”, “Иргэд малчид орон нутгийн удирдлагын хамтын ажиллагаа хөтөлбөр”* /-ний зардалд 15.2 сая төгрөг,

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3²⁷, 60.3.1²⁸, 60.4²⁹, 60.3.6³⁰, 63 дугаар зүйлийн 63.1³¹, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журмын 4 дүгээр зүйлийн 4.4³², 6.6³³, 6.7³⁴, 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” -ын 6 дугаар зүйлийн 6.3.3³⁵ дахь заалтыг хэрэгжүүлээгүй тул 165.6 сая төгрөгийн төсөл, хөтөлбөрийн зардлыг хасч тодотгуулахаар хугацаатай албан шаардлага өгч аудитын явцад зөрчлийг арилгууллаа.

Энэ нь аймаг, сумын ЗДТГ-ын ажлын хэсэг БИНХ-аас гарсан саналыг нэгтгэхдээ хууль, журамд нийцэж байгаа эсэхийг хяналгүйгээр хууль, журмаар хориглосон ажилд хөрөнгө зарцуулахаар төлөвлөж, ИТХ-ын төлөөлөгчийн олонхийн саналаар баталж байгаатай холбоотой байна.

²⁶ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийн, олонхийн санал авсан дарааллаар нь эрэмбэлж багцална/ум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийн, олонхийн санал авсан дарааллаар нь эрэмбэлж багцална

²⁷ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно.

²⁸ Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ

²⁹ Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй.

³⁰ Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

³¹ Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

³² Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх болон урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй

³³ Аймаг нийслэлийн Засаг даргад иргэд, олон нийтээс хамгийн их санал, ажлын хэсгийн дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн, иргэд олон нийтэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон иргэний танхимаар дамжуулан 11 дүгээр сарын 30-ны дотор танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулна.

³⁴ Аймаг нийслэлийн ИТХ-нь Аймаг нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг төсөл тус бүрээр хэлэлцэн төсвийн төсөлд тусган “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын сум/ дүүргийн ИТХ-ын хуралдааны тогтоол /загвар маягт/-ын 3 дугаар хавсралтын дагуу батална.

³⁵ хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх

Энэ зөрчил дээрх 2 газарт өмнөх жилд гарч байсан бөгөөд аймаг, сумын ажлын хэсэг, холбогдох албан тушаалтнууд хууль, журамд нийцсэн төсөл, арга хэмжээний жагсаалтыг гарган батлуулж байх, аудитаас өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.

Мөн аймаг, сумын төсөв захирагч нарын төсөвт орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх, хөтөлбөр, арга хэмжээний зардал батлагддаггүй нь нөлөөлж байна.

2.3 Ихэнх сумд хууль, журмын дагуу зураг, төсөв нь хийгдсэн ажлуудыг баталж санхүүжүүлжээ.

Аудитын явцад ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлуудад зарцуулах хөрөнгө, төсөвт өртгийг урьдчилан тооцсон, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан эсэхийг судалж үзэхэд томоохон барилга байгууламжийн зураг төсвийг эрх бүхий байгууллагаар хийлгэж, тоног төхөөрөмж, бусад зүйлийн төсвийг захиалагч байгууллага өөрөө хийсэн байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлын зураг төсвийн зардалд 2014-2015 онд нийт 47 ажлын 662.7 сая төгрөгийн зураг төсөв хийгдсэн бөгөөд 2016 онд аймгийн төв болон 3 суманд сангийн хөрөнгөөр хийгдэх 5 ажлын зураг төсөвт 39.1 сая төгрөг зарцуулжээ.

Өмнөх жилүүдэд зарим сумд, шинээр хийгдсэн ерөнхий төлөвлөгөөг бүртгэл тайланд тусгаагүй, эргэж төлөгдөх зураг төсвийн зардлыг санхүүгийн тайланд авлагаар тайлагнаагүй 97.6 сая төгрөгийн зөрчил илэрч байсан бөгөөд дээрх зөрчил давтан гараагүй байна.

Өнгөрсөн оны аудитаар захиалагч байгууллага ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төсвийг боловсруулахдаа зах зээлийн судалгаа хийлгүйгээр хэт өндөр зардлаар төлөвлөж хэрэгжүүлсэн /60.9 сая төгрөгийн/ зөрчил 4 суманд гарч байсан бол энэ жил 1 суманд гарсан байна.

Тухайлбал: Дэрэн сум “Хүүхдийн цэцэрлэгийн гадна хашаа” шинээр барих ажилд /310 метрийн урттай, 96.5 х 60.5 харьцаатай бетонон суурьтай, төмөр хайсан хашаа/ 31.2 сая төгрөг зарцуулсан байхад Сайнцагаан сумын “4 дүгээр цэцэрлэгийн гадна хашаа” /256 метрийн урттай, төмөр хайсан хашаа/ шинээр барих ажилд 8.0 сая төгрөг зарцуулсан.

(Хавсралт : 10)

Дэлгэрхангай суманд 2016 онд ОНХС-гийн хөрөнгөөр зураг, төсөв нь батлагдаагүй “Нэг цэгийн үйлчилгээний байрны халаалтын систем шинэчлэх” ажилд 10.6 сая төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³⁶, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журмын 4 дүгээр зүйлийн 4.7³⁷, 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай” журмын

³⁶ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

³⁷ Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй.

6 дугаар зүйлийн 6.3.3³⁸ дахь заалтуудыг тус тус зөрчсөн тул зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

2.4. Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажил зарим талаар хууль, журамд нийцээгүй байна.

ОНХС-гийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо болон ажлын хэсгийг аймаг, сумын Засаг даргын захирамж, ЗДТГ-ын даргын тушаалаар 5-7 хүний бүрэлдхүүнтэйгээр томилон ажиллуулсан байна.


Аймаг, сумаас зохион байгуулсан тендерийн үнэлгээний хороонд АЗ сертификаттай эрх бүхий хүмүүс ажиллажээ.

ОНХС-гийн 2016 оны худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1³⁹, 8.2-т заасны дагуу 209 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 169-г зохион байгуулсан.

2016 онд шинээр хэрэгжүүлсэн нийт 209 төсөл, арга хэмжээний 6.2 хувь буюу 13 ажлыг нээлттэй тендер, 27.8 хувь буюу 58 ажлыг харьцуулалтын аргаар, 46.9 хувь буюу 98 ажлыг шууд гэрээ байгуулж, 19.1 хувь буюу 40 ажлыг олон нийтийн оролцоотой болон зөвлөх үйлчилгээний аргыг сонгон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. (Хавсралт :4,5)

Аймгийн хэмжээнд 2016 онд бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг НТШ-13, ХА-58, ШХА-98, ЗҮ-1, ОНО-39 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр НТШ-11, ХА-46, ШХА-88, ЗҮ-1, ОНО-23-г зохион байгуулж, бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагаанд хууль журмыг мөрдөж ажиллажээ. (Хавсралт 4,5)

График 5



³⁸ хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх

³⁹ Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараахь босго үнийг тогтооно:

Дээрх графикаас харахад ихэнх ажлууд нь ХА болон ШХА-аар хийх ажлууд төлөвлөгдөж хийгдсэн байна.

2016 онд НТШ, ХА, ШХА-аар хийх ажлын гүйцэтгэл буурсан нь төлөвлөсөн ажлаас 44 ажил хийгдээгүйтэй холбоотой байна.

Нээлттэй тендер шалгаруулалт, харьцуулалтын аргаар хийх ажлыг шууд худалдан авалтын аргаар хийж хөрөнгө зарцуулсан зөрчил сумдад гарсан.

Тухайлбал:

- Луус, Хулд, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Дэрэн сумд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Инженерийн хийцтэй худаг” гаргах ажлын худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгохдоо босго үнийг мөрдөлгүй шууд худалдан авалт хийсэн.

- Цагаандэлгэр сум ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 16.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Өвс, тэжээл бэлтгэх” ажлын худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгохдоо босго үнийг мөрдөлгүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн, 8.1⁴⁰, 8.1.2⁴¹, 8.4⁴², 33 дугаар зүйлийн 33.1⁴³, 34 дүгээр зүйл 34.1⁴⁴, 34.1.1.- 34.1.7.- дахь заалт, 34.3⁴⁵, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4⁴⁶, 24 дүгээр зүйлийн 24.4⁴⁷ дэх заалтуудтай нийцэхгүй байна.

Дээрх зөрчил сумын Засаг даргын орлогч, сумын Засаг дарга нар нь хууль, журмыг мөрддөггүй, төсвийн хөрөнгийг хяналтгүй зарцуулж байгаатай холбоотой байна.

Хүнс хөдөө аж ахуйн яамнаас аймагт, хөдөөгийн хүн ам, мал аж ахуйн усан хангамжийн өрөмдлөгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг эзэмшигч “Элбэгсанчир ХХК”-ний үйл ажиллагааг дэмжих зорилгоор тус байгууллагаар “Инженерийн хийцтэй худаг” гаргах ажлыг гүйцэтгүүлэхийг, тухайн үеийн аймгийн Засаг дарга сумдад үүрэг болгосон.

Энэ нь тендер шалгаруулалтад оролцох сонирхолтой, орон нутагт ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудын

⁴⁰ .Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно.

⁴¹ Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар

⁴² Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

⁴³ Бараа ажил үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно.

⁴⁴ Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараах нөхцөлд хэрэглэж болно.

⁴⁵ Энэ хуулийн 34.1.-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

⁴⁶ Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох

⁴⁷ Төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно

өрсөлдөөнийг хязгаарлаж, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.6⁴⁸, 11.2⁴⁹, дахь заалтуудыг зөрчсөн байна.

Төсвийн тухай хууль болон ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчин худалдан авалт хийж байгаа нь төсвийн хөрөнгө сумын Засаг даргын хууль бус шийдвэрээр үр ашиггүй зарцуулагдах нөхцөл бүрдэж байна. Энэ асуудалд тухайн шатны ИТХ, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журмын 9 дүгээр зүйлийн 9.1⁵⁰, дахь заалтын дагуу хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Тендерийн ерөнхий нөхцөлийг хангаагүй гүйцэтгэгчийг шалгаруулсан зөрчил өмнөх оноос эрс буурсан сайн үзүүлэлт харагдаж байгаа боловч Дэрэн суманд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 49.9 сая төгрөгийн өртөгтэй “Дэрэн, Дэлгэрцогт сумын ургамалжуулах талбайн тэжээлийн үйлдвэр нэмэгдүүлэх ажил”-ын төсөв зохиогч нь гүйцэтгэгч хуулийн этгээдэд зөвлөхөөр ажиллахаар тендерийн материалд ирүүлсэн байхад үнэлгээний хороо тус тендерийг шалгаруулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5⁵¹, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журмын 4 дүгээр зүйлийн 4.5. /Орон нутгийн төсвийн бус байгууллагуудад ОНХС-гаас хөрөнгө зарцуулахгүй байх./ дахь заалтуудад нийцээгүй тул зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгсөн.

Дээрх зөрчил нь худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа ажилтнуудын хууль, эрх зүйн мэдлэг дутмагаас шалтгаалжээ.

2.5 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргийг санхүүжүүлжээ.

Аймаг, сумын ЗДТГ-ын ажлын хэсэг нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7 дугаар зүйл 7.2⁵², 7.4⁵³, дахь заалтуудын дагуу аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүрэгт орсон хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтыг гаргаж нэгтгэн, тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлж батлуулсан байна.

Аймаг, сумын ИТХ нь ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг Төсвийн тухай хуулийн хүрээнд “Орон нутгийн төсвийн төсөл

⁴⁸ Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно.

⁴⁹ Захиалагч техникийн тодорхойлолт бэлтгэхдээ тухайн тендер шалгаруулалтад оролцох сонирхолтой этгээдээс өрсөлдөөнийг хязгаарлахад хүргэж болох зөвлөгөө авахыг хориглоно.

⁵⁰ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө, оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

⁵¹ тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;

⁵² Аймаг ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 58.2 –т заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлж болно.

⁵³ Сум ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 58.4 –т заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлж болно.

боловсруулах журам"-ын 7 дугаар зүйлийн 7.5.7, 7.6.6⁵⁴ дахь заалтуудын дагуу хөрөнгө оруулалт тус бүрээр хэлэлцэн баталжээ.

Аймгийн хэмжээнд 2016 онд 5,529.5 сая төгрөгийг нийт 229 арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж, 4,831.9 сая төгрөгийн 185 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт :3

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Батлагдсан төсөл хөтөлбөр		Хэрэгжсэн төсөл хөтөлбөр		Хэрэгжилтийн хувь	
		тоо	өртөг	тоо	өртөг	тоо	өртөг
1	Дэлгэрцогт	10	150.0	9	122.8	90.0	81.9
2	Дэрэн	12	164.4	11	128.6	91.7	78.2
3	Говь-Угтаал	8	152.0	7	140.9	87.5	92.7
4	Цагаандэлгэр	11	249.5	9	182.0	81.8	72.9
5	Баянжаргалан	6	147.2	3	51.5	50.0	35.0
6	Өндөршил	12	182.9	8	127.2	66.7	69.5
7	Гурвансайхан	11	265.9	6	198.4	54.5	74.6
8	Өлзийт	14	220.1	13	180.7	92.9	82.1
9	Хулд	7	168.9	7	168.9	100.0	100.0
10	Луус	13	140.7	10	110.7	76.9	78.7
11	Дэлгэрхангай	6	173.1	6	173.1	100.0	100.0
12	Сайхан-Овоо	10	162.4	10	158.4	100.0	97.5
13	Эрдэнэдалай	50	224.8	33	160.1	66.0	71.2
14	Сайнцагаан	23	402.5	22	350.1	95.7	87.0
15	Адаацаг	23	160.3	20	112.5	87.0	70.2
16	Аймгийн ОНХС	13	2,564.8	11	2,466.0	84.6	96.1
	Аймгийн нийт дүн	229	5,529.5	185	4,831.9	80.8	87.4

Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад батлагдсан төсөл, хөтөлбөрийн тоо 19–өөр нэмэгдэж, санхүүжилт 3,919.5 сая төгрөгөөр буурсан, хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн тоо 7–гоор нэмэгдэж, санхүүжилт 2,949.2 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. (График: 6, Хүснэгт 3)

⁵⁴ Аймаг сум дүүргийн засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтыг төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулан, төсвийн захирагчийн нэр, хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухай төсвийн жилийн санхүүжилтийн дүнг тусгана.

нээлттэй хэлэлцүүлэн санал авч, эрэмбэлсэн эсэх/ дахь хэсэгт дэлгэрэнгүй бичигдсэн.

2.6. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд аймаг, сумаас захиалагчийн хяналтыг тавьж ажилласан ч зарим суманд чанаргүй хөрөнгө бэлтгэгдсэн зөрчил арилахгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтнээр ахлуулсан ажлын хэсэг аймаг сумдад хийгдсэн ажлын гүйцэтгэлийн явц, байдалтай газар дээр нь очиж шалгах, мэргэжлийн хүмүүсээс зөвлөгөө авах, өгсөн үүрэг даалгавраа эргэж шалгах, ажил эхлүүлэхээс дуусах хүртэлх бүх шатанд захиалагчийн хяналтыг тавьж Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын дагуу хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Аймаг суманд шинээр баригдаж байгаа их засвар үйлчилгээ, болон бусад чиглэлээр хийгдэж байгаа томоохон ажлын үе шат бүрд аймгийн ГХБХБ-ын албанаас ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46.1.6⁵⁵, дахь заалтын дагуу явцын хяналтыг хийж хяналтын тайланг гаргаж ажиллажээ.

2016 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудаас нийт 47.6 сая төгрөгийн хяналтын зардал авч зарцуулахаас гүйцэтгэлээр 47.6 сая төгрөг буюу 100 хувь авсан байна. (Хавсралт: 3)

2016 онд иргэдийн тогтвор суурьшилтай амьдрал, аж байдалд эерэг таатай нөлөөлөл бий болгох, иргэдэд ажлын байр бий болох, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжсэн ээлтэй орчинг бүрдүүлсэн томоохон хөрөнгө оруулалтуудыг хийсэн байна. Тухайлбал:

- Аймгийн төв 2,143.7 сая төгрөгийн “Цэнгэлдэх хүрээлэн Мандалговь цэцэрлэгт хүрээлэн байгуулах” ажлын хүрээнд “А” блокийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулсан,
- 644.7 сая төгрөгийн “Өвлийн нарлаг хүлэмж” шинээр барьж ашиглалтад оруулсан,
- 2,444.1 сая төгрөгийн “Сүм хөх бүрд цогцолборын байгалийг нөхөн сэргээх, дэд бүтэц цахилгаан дамжуулах шугам, дэд өртөөний барилга байгууламж, ногоон байгууламжийн ажлыг гүйцэтгүүлж ашиглалтад оруулсан.
- Өндөршил сум 34.5 сая төгрөгийн “Ахмадын байрны засвар”-ын ажлыг гүйцэтгүүлж ашиглалтад оруулсан,
- (Хавсралт 15-18)

Аймаг, сумаас захиалагчийн хяналтыг ажлын үе шат бүрд хэрэгжүүлж ажилласан ч зарим суманд бэлтгэн нийлүүлэгч, захиалагчтай хийсэн гэрээний заалтыг зөрчин дутуу, чанаргүй хийсэн хөрөнгийг санхүүжүүлсэн нь сангийн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдаж орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Тухайлбал:

- Дэрэн суманд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 49.9 сая төгрөгийн өртөгтэй “Дэрэн, Дэлгэрцогт сумын ургамалжуулах талбайн тэжээлийн үйлдвэр нэмэгдүүлэх ажил”

⁵⁵ Бараа ажил үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавина

Аудитын явцад гүйцэтгэсэн ажилтай танилцахад тендерийн баримт бичигт тусгагдсан ажлаас зөрүүтэй, үр дүн муутай байдал харагдаж байлаа.

- Гурвансайхан сум 65.4 сая төгрөгийн “Их газрын чулууны уулын задгай театрын тайзны засал тохижилт дэд бүтэц” –ийн ажил

Аудитын явцад гүйцэтгэсэн ажилтай танилцахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ өндөр боловч, хийгдсэн ажил бага, сангийн хөрөнгийг үр дүнгүй зүйлд зарцуулагдсан гэж дүгнэхээр байна.

- Аймгийн төв 79.9 сая төгрөгийн “Жуулчны баазуудын хоорондох тэмдэг тэмдэглэгээ” хийх ажил /Гэрэлт хөшөө босгох /

Аудитын явцад гүйцэтгэсэн ажилтай танилцахад 8 сумын нутаг дэвсгэрт 17 ширхэг хөшөө босгож тус бүрийг нь 4.7 сая төгрөгөөр орлогод авсан боловч замын маршрут чиглэлийг заасан бичвэр хэтэрхий жижиг, замын тэмдэг нэршил нь зохимжгүй, хөшөөг тойруулж суулгасан чулууны хэлтэрхийнүүд малын хөлөөр ховхорсон байдалтай байгаа нь сангийн хөрөнгийг үр дүнгүй зүйлд зарцуулагдсан гэж дүгнэхээр байна.

(Хавсралт 11-14)

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг сумдад ихэвчлэн ЗДТГ-ын ажилтнууд тавьж байна.

Мэргэжлийн бус хүн захиалагчийн хяналтыг гүйцэтгэж байгаа нь гүйцэтгэгч байгууллагад бүрэн шаардлага тавьж чаддаггүй, зайлшгүй шаардлагатай багаж, тоног төхөөрөмжгүй зэрэг хүндрэл гарч, ОНХС-гаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр үр дүнгүй болох нөхцөл шалтгаан болж байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд аймаг, сумын ИТХ, Засаг даргын хяналт сул байдгаас чанаргүй хөрөнгө хийгдэж төсөв үр дүнгүй зарцуулагдах, хөрөнгийн бүртгэл хадгалалт, хамгаалалт сулрах, эзэнгүйдэх зэрэг зөрчил арилахгүй байгаад дүгнэлт хийж ажиллах нь зүйтэй .

Гэрээний хугацаанд ажлаа хийж дуусгаагүй байхад санхүүжилт олгосон зөрчил өмнөх оноос эрс буурсан сайн үзүүлэлт харагдаж байгаа ч Өлзийт суманд нийт 48.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Инженерийн хийцтэй худаг” гаргах ажлын гүйцэтгэгч “Экогео” ХХК, Цахиурт баян ХХК –иудад нийт ажлын санхүүжилтийг 100 хувь олгосон боловч гэрээний хугацаанд ажлыг бүрэн гүйцэтгүүлж хүлээн аваагүй байна.

Аудитын явцад тодруулахад: “Гүйцэтгэгч байгууллагууд, зарим газрын гүний худгийн ус бага, хуурай ан цавтай учир эдгээр шалтгаануудаас болж зарим худгийн хайгуулын цэгийг дахин тавьж өрөмдөх учир ажил хугацаандаа амжихгүй болсон. Иймээс 2017 оны 4-5 сард ажлыг бүрэн дуусгаж хүлээлгэн өгөх саналтай байна.” гэсэн хүсэлтийг ирүүлжээ.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 40.3⁵⁶ дахь заалтад заасан нөхцөлийг гэрээнд нарийвчлан тусгаж өгөөгүй, Иргэний тухай хуулийн 350.1.1⁵⁷, 351.1.2⁵⁸ дахь заалттай нийцэхгүй байна.

2.7 Өлзийт, Сайхан-Овоо сумд ОНХС-гийн санхүүжилтээр бий болсон 30.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаагүй байна.

ОНХС-гийн дансанд 866.6 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг /9 сум малжуулах төслийн мал/ бүртгэж тайлагнажээ. Сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг аймаг, сумын Засаг даргын захирамжаар томилогдсон эрх бүхий комиссын актаар хүлээн авч, ИТХ-ын шийдвэрээр ЗДТГ болон хөрөнгийг ашиглагч байгууллагын бүртгэл тайланд тусгасан. (Хүснэгт: 5)

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 4,227.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэснээс аймаг сумын ЗДТГ болон бусад төсөвт байгууллагад 4,196.3 сая төгрөгийг бүртгэлд тусгаж, 30.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байсан зөрчлийг арилгуулахаар аудитын явцад албан шаардлага өглөө.

Тодруулбал:

- Өлзийт сум 13.7 сая төгрөгийн өртөгтэй “Сургуулийн дотуур байрны халаалт, ариун цэврийн өрөөний тохижилт”-ын ажил,
- Сайхан-Овоо сум 12.0 сая төгрөгийн өртөгтэй “Сумын төвийн худгуудын засварын”-ын ажил,
- Сайхан-Овоо сум 5.0 сая төгрөгийн өртөгтэй “Сургуулийн оюуны хөгжил төвийн засвар”-ын ажлыг тус тус бүртгэл тайланд тусгаагүй.

ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁵⁹, 14.4.2⁶⁰, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Орон нутгийн хуулийн этгээдийн олж авсан эд хөрөнгийг бүртгэх”-журмын 3 дугаар зүйлийн 3.2⁶¹ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Сайхан-Овоо суманд ОНХС-гийн хөрөнгөөр шинээр баригдсан 40.0 сая төгрөгийн өртөгтэй “Найз баг”, “Мааньт баг”-ийн төвийн барилгуудад хувийн хэрэг нээж хөтлөөгүй зөрчил илэрч, зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлсэн.

Дээрх зөрчил нь Барилгын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1⁶², Барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 71 дүгээр тушаалаар баталсан “Барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл, их засварын хувийн хэрэг хөтлөх” журмын хавсралт 1-ийн 1.2⁶³ дахь заалтуудыг зөрчсөн тул захиалагч байгууллагын дарга, эрхлэгч нарт албан шаардлага өгч аудитын явцад зөрчлийг арилгууллаа.

⁵⁶ Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараах нөхцөлийг заавал тусгана.

⁵⁷ Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх.

⁵⁸ Гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах

⁵⁹ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ

⁶⁰ бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

⁶¹ Улсын хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан Улсын комисс /Ажлын хэсэг/-ын акт, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн зохих баримт материалыг үндэслэн тухайн төсөл хэрэгжсэн байгууллага нь тайлан балансдаа шууд бүртгэн авна.

⁶² Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл, их засварын тухай төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмын дагуу хувийн хэрэг хөтөлнө

⁶³ Барилгын тухай хуулийн 3.1.4-д заасан "барилга байгууламж" гэсэн тодорхойлолтод хамаарагдах Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдсан, бүх төрлийн барилга байгууламжийн /гадаад улс, олон улсын байгууллага,

Дэрэн суманд сангийн хөрөнгөөр засвар хийж тохижуулсан “Ахуйн үйлчилгээний барилга”, Дэлгэрхангай суманд засвар хийж тохижуулсан “Халуун усны барилга”, Говь-Угтаал суманд засвар хийж тохижуулсан “Ахмадын сувиллын барилга”, Өлзийт суманд шинээр баригдсан Хүнс, цайны газрын барилгад тогтмол үйл ажиллагаа явуулж зориулалтын дагуу ашиглаагүй нь Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2⁶⁴, 7.2.7⁶⁵, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2⁶⁶, 14.2-ийн 1⁶⁷, 26 дугаар зүйлд⁶⁸ дахь заалтыг зөрсөн тул зөрчлийг арилгуулах, бий болсон хөрөнгийг үр дүнтэй ашиглах ажил зохион байгуулах талаар аудитын явцад зөвлөлөө.

Дээрх зөрчил нь орон нутгийн хэрэгцээ шаардлагыг харгалзалгүй, зах зээлийн судалгаа, өмч хөрөнгийн урсгал зардлын тооцоог урьдчилж тооцоололгүй хөрөнгө бэлтгэж байгаатай холбоотой бөгөөд сангийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгө үрэгдэх шамшигдах нөхцөл байдал үүсэх эрсдэлтэйг харуулж байна.

Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд нийт 2,162.6 сая төгрөгийн өр төлбөр, 808.3 сая төгрөгийн авлагыг тус тус тайлагнасан. (Хүснэгт: 5)

Зарим сумдын Орон нутгийн хөгжлийн сан хариуцсан нягтлан бодогч нар тайлант онд үүссэн авлага, өр төлбөрөө бүртгээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁶⁹, 14.4.2⁷⁰, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Орон нутгийн хуулийн этгээдийн олж авсан эд хөрөнгийг бүртгэх”-журмын 3 дугаар зүйлийн 3.2⁷¹ дахь заалтыг зөрчсөн тул зөрчлийг арилгуулахаар 3 суманд 101.4 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

Хүснэгт 4

Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд бүртгэсэн хөрөнгө, өглөг, авлага болон баталгаажуулаагүй өглөг, авлагын судалгаа /2016 он/

/Сая,төг/

гадаадын иргэдийн өмчийн болон тэдний мэдлийнхээс бусад/ хувийн хэргийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр заавал хөтөлнө

⁶⁴ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ

⁶⁵ барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавих

⁶⁶ Төрийн байгууллага, албан газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй

⁶⁷ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах/

⁶⁸ Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана/

⁶⁹ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ

⁷⁰ бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

⁷¹ Улсын хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан Улсын комисс /Ажлын хэсэг/-ын акт, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн зохих баримт материалыг үндэслэн тухайн төсөл хэрэгжсэн байгууллага нь тайлан балансдаа шууд бүртгэн авна.

№	Сумын нэр	Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд бүртгэсэн хөрөнгийн судалгаа / мян.төг /		ОНХС-ийн СТА-аар тайлагнасан		Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	
		Дүн	Мал амьтад	Өглөг	авлага	Өглөг	авлага
1	Дэлгэрцогт	45.0	45.0		13.0		
2	Дэрэн	163.4	163.4		8.0		
3	Говь-Угтаал			0.9	29.0		
4	Цагаандэлгэр	40.0	40.0		10.8		10.8
5	Баянжаргалан			0.2	49.0		
6	Өндөршил						
7	Гурвансайхан			1887.5	47.7		
8	Өлзийт	163.3	163.3	3.0	63.7	3.0	63.7
9	Хулд	79.9	79.9				
10	Луус	30.0	30.0				
11	Дэлгэрхангай	117.8	117.8		40.6		
12	Сайхан-Овоо				23.9	-	23.9
13	Эрдэнэдалай			2.2	107.7		
14	Адаацаг	100.0	100.0	0	-	-	
15	Сайнцагаан	127.2	127.2	-	50.5	-	-
16	Аймгийн төв			364,4	268,8		
	Дүн	866.6	866.6	2,162.6	808.3	3.0	98.4

Бүлэг 3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй ч хэрэгжилтийг зааврын дагуу мэдээлсэн байна

3.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба зарим сумдад төлөвлөгөөт шалгалтыг хийсэн байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын *Ес.* “ОНХС-ийн хяналт шинжилгээ ба үнэлгээ” 9.1⁷², 9.4⁷³ дэх заалтуудыг аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо хэрэгжүүлээгүй байна.

⁷² ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

⁷³ Тухайн шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо нь сайн дурын итэвхтэн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ОНХС-аас хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үр дүнд хяналт тавьж, үнэлгээ хийнэ.

Аудитын явцад ОНХС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт, ашиглалтад иргэд хяналт тавих бололцоо, механизм байгаа эсэх талаар иргэдээс авсан санал асуулгаар судалгаанд оролцсон иргэдийн 34.2 хувь нь бүрэн боломжтой, 24.4 хувь боломжгүй, 41.4 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.

Энэ нь судалгаанд хамрагдсан иргэдийн ихэнх хувь нь хууль эрх зүйн мэдлэг дутмаг, ОНХС-гийн талаарх мэдээлэл муу, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллах нөхцөл бүрдээгүй байгааг харуулж байна.

Иймд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, мэдээллийг тэгш, хүртээмжтэй байдлаар олон нийтэд хүргэх, хууль тогтоомжийг сурталчлах талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

Судалгаанд хамрагдсан иргэдээс тус аймагт хэрэгжүүлж буй ОНХС-гийн санхүүжилт, төсөл арга хэмжээний талаар дараах санал хүсэлт илэрхийлжээ. Үүнд:

- ОНХС-ийн дүрэм, журам, ирсэн хөрөнгө, түүнийг зарцуулахаар төлөвлөж байгаа асуудлын талаар иргэд мэдээлэлгүй байдаг, иргэдийг мэдээ, мэдээллээр хангаж байх;
- Хэрэгжүүлж буй төсөл, түүний санхүүжилтэд тавих хяналт муу байна.
- Багийн Засаг дарга нар төсөл, түүний санхүүжилтийн талаар айл өрх, иргэдэд мэдээлэл өгдөггүй;
- Төслийг зөв сонгуулж, зөв зүйлд зарцуулах, зарцуулалтын байдалд тавих хяналтыг сайжруулах;
- ОНХС-ийн хөрөнгө, санхүүжилтийг аймгаас дутуу өгдөг, бүрэн өгч байх,
- сум орон нутагт хуваарилсан хөрөнгийг буцаан татдаг явдлыг зогсоох

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.2-д */ОНХС-гаас оруулж байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг дотоод аудитын алба хэрэгжүүлнэ./* заасны дагуу 2016 онд Адаацаг, Баянжаргалан, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Өлзийт, Сайхан-Овоо, Сайнцагаан зэрэг 7 сумын ОНХС-гийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн дагуу санхүүгийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн байна. Тус алба нь 2017 оны ажлын төлөвлөгөөнд 2016 онд төлөвлөгөөнд тусгагдаагүй үлдсэн 8 сум, аймгийн ОНХС-гийн үйл ажиллагааг шалгахаар тусгаж, ТЕЗ-аар батлуулсан байна.

Тухайн шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо ОНХС-гаас хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд хяналт тавьж, үнэлгээ хийж ажиллаагүй нь ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт үр дүнгүй зарцуулагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Иймд ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын холбогдох заалтыг цаашид хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.

3.2. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу тайланд дүн шинжилгээ хийгдээгүй байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын *Арав.* “ОНХС-гийн тайлагналт” 10.1⁷⁴ дахь заалтын дагуу ажлын хэсэг Засаг даргын захирамжаар томилогдон ажилласан хэдий ч 10.2⁷⁵, 10.3⁷⁶ дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. Ажлын хэсэг ОНХС-гийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт гаргаж, санал зөвлөмж гаргаагүй нь өмнөх алдаа, зөрчлийг давтан гаргах нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд ажлын хэсэг холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмыг мөрдөн ажиллах шаардлагатай.

3.3. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу ил тод бүрэн мэдээлжээ.

Аймаг болон сумдад ажиллах явцад Мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 11.2.3⁷⁷ дахь заалтын хэрэгжилтийг шалгахад ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг танилцуулсан зурагт хуудас, мэдээ судалгааг бүх /15/ сум хийсэн байна. Мөн баг олон нийтийн хуралд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлын тайлангаа танилцуулж, үзүүлэн зурагт хуудас, танилцуулах самбар ажиллуулж иргэд, олон нийтэд мэдээллийг хүргэсэн хэдий ч иргэдийн оролцоо бага, мэдээллийн хүртээмж, үр дүн муутай байна.

Аудитын явцад мэдээллийн хүртээмж, үр дүнтэй байгаа эсэх талаар иргэдээс авсан санал асуулгаар судалгаанд оролцсон иргэдийн 27.4 хувь нь хангалттай мэдээлэлтэй, 40.2 хувь нь сайн мэдэхгүй, 32.4 хувь энэ талаар огт мэдээлэлгүй гэсэн судалгааны дүн гарсан нь мэдээлэл олон нийтэд төдийлөн хүртээмжтэй биш үр дүн муутай байгааг харуулж байна. Иймд аль болох иргэдийн оролцоо, БИНХ-ын хурлын ирцийг нэмэгдүүлэх, мэдээллийг хүртээмжтэй байдлаар олон нийтэд хүргэх талаар анхаарч ажиллах нь зүйтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд аймгийн хэмжээнд 2016 оны ОНХС-гийн төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг бүрэн байршуулсан байна. Энэ нь 2016 оны 01 сарын 11-ний өдрийн ЗГ-ын 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д ОНХС-гийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээг ТЕЗ-ийн шилэн

³ Сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг хил бүрийн 7 дугаар сарын 10-ний өдрийн дотор, бүтэн жилийн тайланг 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ. ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажиллуулна.

⁴ Ажлын хэсэг ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг сум, дүүрэг бүрээр гарган аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол тухайн шатны ИТХ-аар жил бүрийн 2 дугаар сарын 25-ний өдрийн дотор хэлэлцүүлнэ.

⁵ Аймаг, нийслэл ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн тайлан, гарсан санал зөвлөмжийн хамт жил бүрийн 3 дугаар сарын 10-ны дотор Сангийн яамны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хэлтэст ирүүлнэ.

⁷⁷ Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь тухайн орон нутагт ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг ЗДТГ-ын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд тогтмол мэдээлэх бөгөөд санхүүжилт хийгдэх тухай бүр мэдээллийг шинэчлэж байна.

дансны цахим хуудсанд мэдээлэхээр журамлаж өгсөн, журмын хэрэгжилтэд ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба улирал бүр хяналт тавьж, 2016 оны 3-р улирлын байдлаар төлөвлөгөөт шалгалт хийжээ. Мөн аймгийн Аудитын газраас YAГ-ын нэгдсэн удирдамжаар 2016 оны 1, 3-р улирлын байдлаар “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д 2 удаа нийцлийн аудит хийгдсэн нь мэдээллийг хууль, журмын дагуу бүрэн байршуулахад нөлөөлсөн байна.

3.4. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь бусад хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь Төсвийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйл болон ОНХС-г хэрэгжүүлэхтэй холбоотой мөрдөгдөж буй хууль, тогтоомжтой нийцсэн байна.

3.5. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

ОНХС-гийн 2015 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар нийт 2,533.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн, залруулах боломжтой 1,777.7 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2,529.3 сая төгрөгийн 44 албан шаардлага, 4.0 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 16 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2016 онд тус аудитаар 2,533.3 сая төгрөгийн 45 санхүүгийн үр өгөөжийг бүртгэж, нийт үр өгөөжийг бүрэн хэрэгжүүлэн тооцож, маягтын дагуу тайланг гаргаж өгсөн.

ОНХС-гийн аудитаар илэрсэн зөрчлийн дүнг өмнөх аудитын дүнтэй харьцуулж үзэхэд илэрсэн зөрчлийн дүн өмнөх оноос нийт дүнгээрээ буурсан үзүүлэлттэй байгаа боловч, залруулагдаагүй алдаа зөрчлийн дүн 534.1 сая төгрөгөөр өссөн байна. Зөрчлийг агуулгаар нь авч үзвэл өмнөх онд гарч байсан зөрчлүүд дахин давтагдан гарч байна.

Хүснэгт 5

2016, 2017 онд ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад хийгдсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн судалгаа

Он	Илэрсэн зөрчлийн дүн	Залруулсан алдааны дүн	Залруулаагүй алдааны дүн	/ сая.төг /	
				Тогтоогдсон Акт	Албан шаардлага
2016	2,363.3	1,777.6	585.7	4,0	2,359.3
2017	1,119.8		1,119.8	-	1,119.8
Өсөлт бууралт	-1,243.5	- 1,777.6	534.1	4.0	-1,243.5

Аудитаар илэрсэн зөрчил, эх үүсвэрийн харьцааг жилээр харьцуулахад 2014 онд 83.6 хувийг, 2015 онд 27.2 хувийг, 2016 онд 20.4 хувийг тус тус эзэлж байгаа нь жил ирэх тусам зөрчлийн хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

(График : 7)



2016 оны зарцуулалтад хийсэн аудитаар нийт 1,119.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх оноос 1,243.5 төгрөгөөр, эх үүсвэртэй нь харьцуулахад 6.8 хувиар буурсан боловч өмнө гарсан зөрчлүүд арилахгүй, их бага хэмжээгээр давтагдаж байна.

Энэ нь орон нутгийн удирдлагууд сангийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, журам, зааврыг мөрдөхгүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, дээд шатны

удирдлагаас зөрчил гаргасан албан тушаалтнуудтай хариуцлага тооцохгүй байгаатай холбоотой байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Аймгийн ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн.
2. ОНХС-гийн эх үүсвэрийг хуульд заасан төрөл тус бүрээр төлөвлөх, бүрдүүлэх ажил хангалтгүй байна
3. ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг журмын дагуу тооцон хуваарилж, төлөвлөгөөний дагуу санхүүжилтийг бүрэн олгожээ.
4. Зарим сумд тухайн орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн байна.
1. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г иргэдэд нээлттэй хэлэлцүүлэн санал авч эрэмбэлсэн боловч иргэдийн оролцоог бүрэн хангаагүй байна.
2. Ихэнх сумд хууль, журмын дагуу зураг, төсөв нь хийгдсэн ажлуудыг баталж санхүүжүүлжээ.
3. Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил зарим талаар хууль, журамд нийцээгүй байна.

4. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргийг сангаас санхүүжүүлжээ.
5. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд аймаг сумаас, захиалагчийн хяналтыг тавьж ажилласан ч зарим суманд чанаргүй хөрөнгө бэлтгэгдсээр байна.
6. Өлзийт, Сайхан-Овоо сумд ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон 30.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байна.
7. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба зарим сумдад төлөвлөгөөт шалгалтыг хийсэн байна.
8. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу тайланд дүн шинжилгээ хийгдээгүй байна.
9. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу ил тод бүрэн мэдээлжээ.
10. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь бусад хууль тогтоомжтой нийцсэн байна.
11. Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байгаа боловч өмнөх онд илэрсэн зөрчлүүд давтан гарсаар байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймаг, сумдын ИТХ-ын дарга нарт:

1. Аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгч нарт Төсвийн тухай хууль, ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой журам, зааврыг сурталчлан таниулах, сургалт хийх ажлыг зохион байгуулах.
2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд холбогдох хууль, дүрэм, журмаар зөвшөөрөгдөөгүй төсөл арга хэмжээг батлахгүй байх.
3. ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт тавьж үнэлгээ хийх ИТХ-ын дэргэдэх хяналтын хороог Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу байгуулж ажиллуулах,

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт:

1. ОНХС-гийн эх үүсвэрийг хуульд заасан төрөл тус бүрээр бодитой төлөвлөж сангийн орлого нэмэгдүүлэхэд санаачилгатай ажиллах;
2. Төсвийн тухай хууль, ОНХС-гийн зарцуулалттай холбоотой заавар, журмыг иргэдэд таниулах, төсөв төлөвлөх, бүрдүүлэх хуваарилах тайлагнах, хянах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах чиглэлээр иргэдэд тасралтгүй мэдээлэл хүргэх ажлыг эрчимжүүлэх;

3. ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой хууль, дүрэм журмыг мөрдөж ажиллах, хууль, журмаар зөвшөөрөгдөөгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлэхгүй байх;
4. ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний худалдан авах ажиллагааг олон нийтийн хяналттай, ил тод шударга зарчмаар хуулийн дагуу зохион байгуулах;
5. ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт, ил тод байдалд аймгийн Засаг даргаас тавих дотоод хяналт, шалгалтыг сайжруулж төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх;
6. Сангийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, хөрөнгийг зориулалтаар нь ашиглаж байгаа эсэхийг хянаж, үр дүнг тооцож ажиллах;
7. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлж, ОНХС-гийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг сум тус бүрээр гаргуулж байх;
8. Өмнөх жилүүдэд гарсан зөрчил давтагдан гарч байгаад дүгнэлт хийж ажиллах, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх

Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт:

1. Хандив, тусламж болон бусад нэмэлт орлогыг аймаг, сумын ИТХ-аар батлуулж зориулалтын дагуу зарцуулах;
2. Иргэдийн оролцоог бүрэн хангаж ажиллах;
3. ОНХС-гийн хөрөнгийг ИТХ, багийн ИНХ-аар дэмжигдээгүй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд төлөвлөхгүй байх;
4. ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, хөтөлбөр арга хэмжээний худалдан авах ажиллагааг олон нийтийн хяналттай, ил тод шударга зарчмаар хуулийн дагуу зохион байгуулах;
5. ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт, ил тод байдалд сумын Засаг даргаас тавих дотоод хяналт, шалгалтыг сайжруулж төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх.
6. ОНХС-аар бий болсон хөрөнгийг хууль журмын дагуу үнэн зөв бүртгэж, ашиглалтын үр дүнд хяналт тавьж ажиллах;

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГЭХ САНАЛ

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны зарцуулалтын байдалд хийсэн нийцлийн аудитаас ҮАГ-т дараах саналыг уламжилж байна. Үүнд:

1. Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 2.2.5 дахь заалтад тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламжийн орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хүргүүлж байна. /Бүлэг 1.2/

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ

Д.ИХБАЯР

АУДИТОР

Х.ГАРАМ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.НАРАНЦАЦРАЛ

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-т заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ажил хариуцсан холбогдох хүмүүст танилцуулж санал тайлбарыг авлаа.



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

48090 Мандалговь, Дундговь аймаг
Утас: 70-59-24-94, Факс: 70-59-28-96

2017.04.26 № 4/466
танай 2017.04.21-ны № 76 -т

Тайлбар санал хүргүүлэх тухай

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

*Алсбаатар
Санал тайлбарын
судлаач танилцаж
сүргүүлэх
И.Оюун
IV/27.*

Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудит хийсэн тайлангийн төсөлтэй танилцаад дараахь санал, тайлбарыг хүргүүлж байна.

Үүнд:

1. ОНХС-ийн хөрөнгийг ихвэчлэн жижиг буюу урсгал шинжтэй арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна гэжээ. Энд байгаа Цахим аймаг хөтөлбөр нь аймгийн хэмжээнд нийтдээ 204 сая төгрөгийн өртөгтэй, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, зардал мөнгө хэмнэсэн томоохон хөрөнгө оруулалтын ажил юм. Энэ ажлыг бүрэн дуусгуулахаар энэ онд мөн төлөвлөн ажиллаж байна.
2. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлж болохгүй, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв батлагдаагүй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг баталсан байна гэжээ. Энэ нь аймаг, сумын төсөв захирагч нарт удирдлагыг хэрэгжүүлэх төсөв хөрөнгө байдаггүй, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 4 жилийн мөрийн хөтөлбөр, тухайн жилийн үндсэн чиглэл төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх тодорхой төсөв хөрөнгө байдаггүйн улмаас ОНХС-нд 150,4 сая төгрөг баталсан байсныг төсвийн тодотголоор ОНХС-ын хөрөнгийн жагсаалтнаас хасч тодотгосон.
3. Зарим сумд "Инженерийн хийцтэй худаг гаргах" ажлын худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгохдоо босго үнийг мөрдөлгүй худалдан авалт хийсэн нь Элбэг санчир ХХК-тай инженерийн хийцтэй худаг гаргуулахаар аймагтай гэрээ байгуулсны дагуу шууд гүйцэтгүүлсэн болно.
4. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлыг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу нийт иргэдийн оролцоог хангах, иргэд олон нийтийн саналыг авах ажлыг зохион байгуулах тал дээр анхаарч ажиллаж байна.

Цаашид анхаарах зүйлсийн талаар: Төсвийн тухай хууль, ОНХС-ийн журам гарсаар орон нутагт тодорхой эрх мэдэл ирсэн ч гэсэн зарим зүйл орон нутгийн хөрсөнд буухгүй байна. Тиймээс дараахь зүйлсийг хууль журамд өөрчлөлт оруулах тал дээр шат шатандаа анхаарч хамтарч ажиллах саналтай байна.

- Тухайн орон нутагт нэн түрүүнд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, хөтөлбөр, арга хэмжээг бодлогын түвшинд шийдвэрлэх боломжтой хууль, эрх зүйн талаар гарц гаргалгааны талаар зөвлөн туслах.
- Иргэдээс гарсан саналыг эрэмбэлэхэд аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, тухайн жилийн үндсэн чиглэл төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл хөтөлбөр арга хэмжээний санал гарч, ашиглалтгүй хөрөнгө ихтэй болсон нь асуудал болж байгааг анхаарч үзэх.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой нийтлэг зөрчил дутагдлын тал дээр цаашид бид анхаарч, бүх сумдад танай байгууллагаас ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн дагуу үүрэг чиглэл өгч, дахин зөрчил дутагдал гаргахгүй байх тал дээр хяналт тавьж ажиллах болно.

